



ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2016 оны 11 сарын 11 өдөр

Дугаар А/42

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Нийгмийн даатгалын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсэг, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2016 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн “Тэтгэвэр авагч банкаа сонгох ажлыг эхлүүлэх тухай” А/233 тоот тушаал, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2010 оны 25 тоот тогтоолоор баталсан “Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмжийн үйлчилгээ үзүүлэх арилжааны банктай хамтран ажиллах журам”-ын 2.4 дэх хэсгийг тус тус үндэслэн тэтгэвэр авагч тэтгэврээ өөрийн сонгосон банкаар хүлээн авах боломжийг бурдүүлэх, нийгмийн даатгалын үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай, чирэгдэлгүй хүргэх зорилгоор ТУШААХ нь:

Нэг. “Тэтгэвэр авагч тэтгэвэр авах банкаа сонгох, өөрчлөхтэй холбоотой үйлчилгээ үзүүлэх журам”-ыг нэгдүгээр, “Нийгмийн даатгалын сангаас (цэргийн) тэтгэвэр тогтоолгон авч байгаа тэтгэвэр авагчдын банкаа өөрчлөх хүсэлт”-ийн загварыг хоёрдугаар, “Нийгмийн даатгалын сангаас (цэргийн) тэтгэвэр тогтоолгоо аймаг (сум), дүүргийн Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтэс (байцааг)-т гаргах өргөдөл”-ийн загварыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

Хоёр. Шинээр тэтгэвэр тогтоолгох иргэдийн тэтгэврийг “Тэтгэвэр авагч тэтгэвэр авах банкаа сонгох, өөрчлөхтэй холбоотой үйлчилгээ үзүүлэх журам”-ын дагуу 2016 оны 11 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн сонгосон банкаар нь олгох, одоо тэтгэвэр авч байгаа тэтгэвэр авагч тэтгэвэр авах банкаа өөрчлөх боломжийн талаар зар түгээх, хүсэлтийг нь хүлээн авч шийдвэрлэх ажлыг 2016 оны 12 дугаар сарын 15-ны өдрөөс тус тус зохион байгуулан хэрэгжүүлж ажиллахыг аймаг, дүүргийн Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтсийн дарга наарт үүрэг болгосугай.

Гурав. Тэтгэвэр авагч тэтгэвэр авах банкаа сонгох ажлыг эхлүүлж байгаатай холбогдуулан 2016 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн дотор тэтгэврийн програм хангамжид өөрчлөлт оруулж аймаг, дүүргийн Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтсүүд тэтгэврийн программыг тогтооосон хугацаанд ашиглах боломжийг бурдүүлж ажиллахыг Мэдээллийн технологийн төв (Г.Хүрэлбаатар), аймаг, дүүргийн Эрүүл мэнд, нийгмийн даатгалын албадыг мэргэжил, арга зүйгээр ханган, зохион байгуулсан ажлын үр дүнг тооцож ажиллахыг Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилт, судалгааны газар (Ц.Ганцэцэг)-т тус тус даалгасугай.

Дөрөв. Тэтгэвэр авагч тэтгэвэр авах банкаа сонгох, өөрчлөх ажлын явц, үр дүнг 2016 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн дотор Газрын даргын зөвлөлд танилцуулахыг Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилт, судалгааны газар (Ц.Ганцэцэг), Санхүү бүртгэлийн газар (Б.Даваахүү)-т тус тус үүрэг болгосугай.

Тав. Энэ тушаал гарсантай холбогдуулан Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2014 оны “Өргөдлийн загвар батлах тухай” А/152 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Д.ЗОРИГТ

Эрүүл мэнд, нийгмийн даатгалын
өрөнхий газрын даргын 2016 оны 11
дүгээр сарын 11.-ны өдрийн 07.дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт

ТЭТГЭВЭР АВАГЧ ТЭТГЭВЭР АВАХ БАНКАА СОНГОХ,
ӨӨРЧЛӨХТЭЙ ХОЛБООТОЙ ҮЙЛЧИЛГЭЭ
ҮЗҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг. Зорилго

1.1. Тэтгэвэр авагчдын тэтгэврийг хугацаанд нь шуурхай олгох, тэтгэвэр авагч өөрийн сонгосон банкаар тэтгэврээ авах боломжийг бүрдүүлэх, тэтгэврийн олголтод хяналт тавих, хариуцлага хүлээлгэх, нийгмийн даатгалын үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай, чирэгдэлгүй үзүүлэх, харилцагч банк, даатгуулагч (иргэд), тэтгэвэр авагчдад банкаа өөрчлөх мэдээллийг шуурхай хүргэх, сурталчилах ажлыг зохион байгуулах, тэтгэвэр авагчдын банкаа сонгох, өөрчлөхтэй холбоотой мэдээллийн нууцлалыг хадгалах, хамгаалах харилцааг зохицуулахад энэ журмын зорилго оршино.

1.2. Тэтгэвэр авагчдад энэ журмын 1.1-д заасан үйлчилгээг үзүүлэхдээ Нийгмийн даатгалын тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай, Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль болон энэ журмыг мөрдлөг болгоно.

Хоёр. Хамрах хүрээ

2.1. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэг, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2016 оны "Тэтгэвэр авагч банкаа сонгох ажлыг эхлүүлэх тухай" А/233 дугаар тушаал, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2010 оны 25 тоот тогтоолоор баталсан "Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмжийн үйлчилгээ үзүүлэх арилжааны банктай хамтран ажиллах журам"-ын 2.4 дэх хэсгийг тус тус үндэслэн энэхүү журмыг боловсруулав.

2.2. Энэхүү журмыг аймаг, дүүргийн Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтсүүд тэтгэврийн эрхийн харилцаа хэрэгжиж эхлэх даатгуулагч (иргэд) болон тэтгэвэр авах эрх үүссэн тэтгэвэр авагчид тэтгэвэр авах банкаа сонгох, өөрчлөхтэй холбогдон гарах үйл ажиллагаанд мөрдөж ажиллана.

Гурав. Үндсэн хэсэг

Энэхүү журмыг аймаг, дүүргийн Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтсүүд дор дурдсанаар хэрэгжүүлнэ. Үүнд:

3.1. Шинээр тэтгэвэр тогтоолгох иргэдээс тэтгэврээ авах банк (салбар)-ны нэр, дансны дугаарыг "Нийгмийн даатгалын сангаас (цэргийн) тэтгэвэр тогтоолгоо аймаг (сум), дүүргийн Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтэс (байцаагч)-т өргөдөл гаргах нь" маягтын дагуу бичүүлэн авч тэтгэврийн хувийн хэрэгт нь хавсаргана.

3.2. Энэхүү журмын 1.2-т заасан хуулиудын дагуу тэтгэвэр тогтоолгон авч байгаа иргэдийн тэтгэврээ авах банкаа өөрчлөх хүсэлтийг энэ тушаалын хоёрдугаар хавсралтаар баталсан "Нийгмийн даатгалын сангаас (цэргийн) тэтгэвэр авах банкаа өөрчлөх тухай аймаг (сум), дүүргийн Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтэс (байцаагч)-т хүсэлт гаргах нь" маягтын дагуу хүлээн авч тэтгэвэр олгох банкыг нь өөрчлөх асуудлыг шийдвэрлэнэ. Зайлшгүй шаардлагатай тохиолдолд тэтгэвэр авагч дахин хүсэлтээ гаргаж тэтгэвэр авах банкаа өөрчилж болно.

3.3. Тэтгэвэр авагч тэтгэвэр барьцаалсан зээл авсан тохиолдолд зээлийн харилцаа дуусгавар болсны дараа банкаа өөрчлөх хүсэлт гаргах ба энэ тохиолдолд тэтгэвэр авагч банкнаас тэтгэврийн зээлгүйг нотлох тодорхойлолт, тэтгэврийн дэвтрийг авчирна.

3.4.Тухайн нутаг дэвсгэрт түр оршин сууж буй тэтгэвэр авагч тэтгэврийн хувийн хэрэг нь хадгалагдаж байгаа үндсэн харьяллын аймаг, дүүргийн Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтэст хандаж тэтгэвэр авах банкаа өөрчлөх хүсэлтээ гаргана.

3.5.Тэтгэврийн байцаагч банк өөрчлөх тухай хүсэлт гаргасан тэтгэвэр авагчийн бүртгэлийг тухай бүр хөтөлж, банкны нэр, дансны дугаарыг мэдээллийн санд үнэн зөв оруулна.

3.6.Тэтгэвэр авагч банкаа өөрчлөх хүсэлт гаргаагүй тохиолдолд тэтгэврийг нь авч байсан банкаар нь үргэлжлүүлэн олгоно.

3.7.Тэтгэвэр авагчийн банкаа өөрчилсөн тухай мэдээллийг энэ журмын 3.5-д заасан бүртгэлийг үндэслэн тэтгэврийн програмын "банк сонгох" цэсийг ашиглан үнэн зөв оруулна.

3.8.Тэтгэвэр авагчдын олгосон болон олгогдоогүй тэтгэврийн олголтыг тэтгэврийн байцаагч болон Нийгмийн даатгалын үйлчилгээний тасгийн дарга сар бүр хянаж, илүү, дутуу олгогдсон тохиолдолд зөрүүг арилгаж ажиллах ба хяналт шалгалтын байцаагч тэтгэвэр авагчийн банк өөрчилсөн хөдөлгөөн, тэтгэврийн олголтод улирал бүр дотоодын хяналт тавьж ажиллана.

3.9.Тэтгэврийн байцаагч тэтгэвэр авагчдын тэтгэвэр авах банкаа сонгох, өөрчлөхтэй холбоотой мэдээллийн нууцлалыг хадгалах үүргийг хүлээнэ.

3.10.Банк, даатгуулагч (иргэд) болон тэтгэвэр авагчдад тэтгэвэр авах банкаа сонгох, өөрчлөх үйл ажиллагаатай холбоотой үнэн зөв мэдээлэл хүргэх, сурталчилах ажлыг Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтсүүд зохион байгуулна.


3.11.Тэтгэвэр авагч тэтгэвэр авах банкаа сонгоход нийгмийн даатгалын байцаагч хөндлөнгөөс нөлөөлөхийг хориглоно.

Дөрөв. Хариуцлага

4.1.Аймаг, дүүргийн Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтэс тэтгэвэр авагчдын сар бүрийн тэтгэврийн олголтын файл бэлтгэх үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулж, файл бэлтгэхэд гарч буй зөрчлийг дахин гаргахгүй байх талаар холбогдох арга хэмжээ авч ажиллана.

4.2.Тэтгэвэр авагчийн овог нэр, банкны нэр, тэтгэврийн хэмжээ болон бусад мэдээллийг мэдээллийн санд зөрүүтэй оруулснаас тэтгэвэр нь илүү, дутуу олгогдсон тохиолдолд буруутай холбогдох албан тушаалтанд Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

---oo---





Эрүүл мэнд, ниймийн даатгалын ерөнхий газрын даргын 2016 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 42-дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

Нийгмийн даатгалын сангаас (цэргийн) ТЭТГЭВЭР авах банкаа өөрчлөх тухай
_____ аймаг (сум), дүүргийн Эрүүл мэнд, нийгмийн
даатгалын хэлтэс (байцаагч)-т хүсэлт гаргах нь:

Дугаар

1. Ургийн овог:
 2. Эцэг /эх/-ийн нэр:
 3. Нэр:
 4. Тэтгэврийн дэвтрийн дугаар:
 5. Регистрийн дугаар:
 6. Хүйс: эр
 7. Би дараах банкны дансаар тэтгэврээ авна.

Хүсэлт гаргасан:

Хүсэлт хүлээн авсан:

Нийгмийн даатгалын байцаагч

(зарын үсэг)

Оршин суугаа хаяг:

ANSWER The answer is 1000.

Харилцах утасны дугаар

ЦАХИМ ШУУДАН:

201 ... оны ... сар ... өдөр
өдөр

201 OHB cap

ХҮСЭЛТИЙН ДУГААР:

Хүснэгт хүлээн авсан: аймаг (дүүрэг)-ийн Эрүүл мэнд, Нийгмийн даатгалын хэлтсийн байцаагч (ажилтан)

Харилцах утасны дугаар: Хүснэгтийн дугаар:

Хүсэлт хүлээн авсан: 201 . . . он . . . сар . . . өдөр



Эрүүл мэнд нийгмийн даатгалын ерөнхий
газрын даргын 2016 оны 11 дүгээр сарын... -ний
өдрийн М.И.Л. дугаар тушаалын гуравдугаар
хавсралт

Нийгмийн даатгалын сангаас (цэргийн) ТЭТГЭВЭР тогтоолгоо
аймаг (сум), дүүргийн Эрүүл мэнд,
нийгмийн даатгалын хэлтэс (байцааг)-т өргөдөл гаргах нь:

Дугаар

2. Эцэг /эх/-ийн нэр:

1. Ургийн овог:

3. Нэр:

4. Регистрийн дугаар:

5. Хүйс: эр эм

6. Тэтгэврийн төрөл:

Энгийн тэтгэвэр: Өндөр насны Тахир дутуугийн Тэжээгчээ алдсан

Цэргийн албан хаагчийн тэтгэвэр:

Цэргийн алба хаасны Тахир дутуугийн Тэжээгчээ алдсан

ҮОМШӨ-ний тэтгэвэр: Тахир дутуугийн Тэжээгчээ алдсан

7. Шимтгэл төлсөн (улсад ажилласан) хугацаа: ... жил ... сар

8. Тэтгэвэр тогтоолгох сарын дундаж цалин хөлс тодорхойлох 5 жил (60 сар)

9. Тэтгэвэр тогтоолгоо бүрдүүлсэн баримт бичгийн жагсаалт. Үүнд:

- Хөдөлмөрийн дэвтэр
- Нийгмийн даатгалын дэвтэр
- Цалингийн тодорхойлолт/1995 оноос өмнөх хугацааны цалин сонговол/
- Иргэний үнэмлэхийн хуулбар
- Архивын лавлагаа
- ЭХМК-ын акт
- Иргэний 2 хувь зураг
- Хүүхдийн гэрчилгээний хуулбар
- Гэрэлтийн баталгааны хуулбар
- Нас барсны гэрчилгээ
- Үйлдвэрэлийн осол тогтоосон тухай акт
-
-

Тайлбар: Дээрхэс тохиорохыг нь √ гэж тэмдэглэнэ.

Миний бие энэхүү өргөдөл, түүнд хавсаргасан холбогдох баримт бичгийн үнэн зөвийг бүрэн хариуцна. Уг баримт бичиг хуурамч, үндэслэлгүй, зөрчилтэй байсны улмаас нийгмийн даатгалын санд учруулсан хохирлыг би бүрэн төлж барагдуулж, хууль тогтоомжид заасан хариуцлагаа хүлээхээ үүгээр нотолж байна.

Миний тэтгэвэр тогтоолгоо бүрдүүлсэн баримт бичгийг хянан үзэж холбогдох хууль тогтоомжийн дагуу тэтгэвэр тогтоон олгоно уу.

Би тэтгэврээ дараах банкны дансаар авна.

Банкны нэр	Дансны дугаар

Өргөдөл гаргасан :

/ _____ /
(гарын үсэг) / _____ /
(нэр)

Өргөдөл хүлээн авсан:
Нийгмийн даатгалын байцааг

(гарын үсэг)

(нэр)

Оршин суугаа хаяг:

Харилцах утасны дугаар

201 ... оны ... сар ... өдөр

×

ӨРГӨДЛИЙН ДУГААР:

Өргөдөл хүлээн авсан: аймаг /дүүрэг/-ийн Эрүүл мэнд, Нийгмийн даатгалын хэлтсийн

байцааг (ажилтан)

Харилцах утасны дугаар: Өргөдлийн дугаар:

201 ... оны ... сар ... өдөр

цахим шуудан:

Өргөдөл хүлээн авсан: 201 ... он ... сар ... өдөр

Боловсруулсан:
Хянасан:
Хувь:2

*Мийдээ
Ганцэг*

/М.Бямбадулам/
/Ц.Ганцэцэг/